



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

Наадамчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 0461, Факс: (976-11) 32 1808
Цахим хаяг: www.uda.ub.gov.mn

2022.05.24 № 01/01/1873
танай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн дагуу манай байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд баталгаажуулах аудит хийгдсэн. Тус Аудитаар илэрсэн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх тухай 2022 оны 02-р сарын 25-ны өдрийн 497 тоот албан бичгээр ирсэн 3 албан шаардлагатай танилцаад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Зөрчил арилгах тухай 164/A 0270465 дугаар бүхий албан шаардлагаар Үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардлыг 10-аас доошгүй хувь хэмнээгүй ажилласан зөрчлийг давтан гаргахгүй, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллана.
2. Зөрчил арилгах тухай 165/A 0270465 дугаар бүхий албан шаардлагаар Албан хаагчдад Үр дүнгийн мөнгөн урамшууллыг хавтгайруулан олгож, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 хариуцлагатай байх, 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтыг мөрдөж ажиллана.
3. Зөрчил арилгах тухай 166/A 0270465 дугаар бүхий албан шаардлагаар Байгууллагын албан хаагчдын гэр бүлд бэлэг тараасан зөрчлийг давтан гаргахгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3 “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж,

байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” заалтыг мөрдөж ажиллана.

Дээрх зөрчлийг цаашид давтан гаргахгүйгээр хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.